АНУ-ын виз мэдүүлэх DS-160 Маягтын Танилцуулга

Улаанбаатар хот, АНУ-ын ЭСЯ

Ерөнхий мэдээлэл

- Цагаачлалын бус виз мэдүүлэх шинэ маягт **DS-160**

- Албан ёсоор ашиглаж эхлэх хугацаа: **2010-04-01**
  - Туршилтын хугацаа: **2010-3-1 нээс 3-р сарын 31 хүртэл**

- Энэхүү маягт нь дараах маягтуудыг орлоно:
  - DS-156 “Цагаачлалын бус виз мэдүүлэх маягт”
  - DS-157 “Цагаачлалын бус виз мэдүүлэх маягтын хавсралт”
  - DS-158 “Цагаалалын бус виз мэдүүлэгчийн холбоо барих хаяг ба ажил эрхлэлтийн байдал”

Виз мэдүүлэгчдэд ашигтай талууд

- Гурван маягтын оронд зөвхөн нэг маягт бөглөх
- Бүгд онлайн – гараар бөглөх зүйл огт байхгүй
- Гэр бүл болон груп виз мэдүүлэгчдийн мэдэлэл – Нэг л удаа оруулсан бол х үн тус бүрт дахиж бөглөх шаардалгагүй
- Хадгалах боломжтой – бүгдийг нэг дор бөглөх шаардлагагүй
- Дахиж виз мэдүүлэхдээ ашиглахын тулд хадгалж болно
- Зөвхөн баталгаажуулсан хуудасыг хэвлэж авах

Виз мэдүүлэх явц

Зөвхөн өргөдлийн маягт өөрчлөгдсөн – виз мэдүүлэх бусад явцад өөрчлөлт орохгүй хэвээр байна

DS-160 маягт бөглөх

1-р алхам – Өргөдлийн маягт руу орох

- https://ceac.state.gov/genniv хаягаар орж
- Зааварчилгааг уншиж дуусаад “Start Application” товчийг дарна



DS-160 маягт бөглөх

2 –р алхам – ЭСЯ-аа сонгох

- Виз мэдүүлэх ЭСЯ-аа буюу Улаанбаатар, Монгол гэж сонгоно.

DS-160 маягт бөглөх

3-р алхам – Зураг оруулах

- Зургаа хайж олоод “Upload Selected Photo” буюу сонгосон зургийг татаж байршуул гэсэн товчийг дарна.
- Хэрэв таны зураг стандартад нийцвэл “Continue Using This Photo” буюу энэ зургийг ашиглан үргэлжлүүл гэсэн товчийг сонгоно.
- Хэрэв таны зураг стандарт хангахгүй бол “Continue Without A Photo” буюу зураггүйгээр үргэлжлүүлэх гэсэн товчийг сонгоно.



DS-160 маягт бөглөх

4-р алхам – Маягт бөглөх

- Асуулт бүрийг нягт нямбай хариулна.
- Буруу мэдээлэл оруулах эсвэл заавал бөглөх асуултыг хоосон орхивол та визний ярилцлаганд орох боломжгүй ба дахиж маягт бөглөж ирүүлэхээр буцаагдах төдийгүй шинээр цаг товлож ярилцлаганд орно.



DS-160 маягт бөглөх

Өргөдлийн маягтийг хадгалах

- Хэрэв та өргөдлийн маягтыг нэг дор бөглөж чадахгүйд хүрвэл компьютерт хадгалан дараа үргэлжлүүлэх боломжтой.
- Тухайн хуудасны доод талд байрлах “Save” буюу хадгалах гэсэн товчийг дарна.
- “Save Application to File” товчийг дарна.
- “Save” товчийг дарж хаана хадгалахаа сонгоно.



DS-160 маягт бөглөх

Хадгалсан өргөдлийг буцааж нээх

- Өргөдөл хадгалсан файлаа хайж олох.
- “Upload Data” буюу татаж байршуулах гэсэн толчийг дарна.



DS-160 маягт бөглөх

Зөвлөмж

- Хэрэв тухайн асуулт танд хамааралгүй бол “Does Not Apply” гэсэн нүдийг сонгоорой
- Бүрэн хариулт өгч аль болох нарийвчилсан мэдээлэл өгөөрэй
- Төгсгөл хавь руу байгаа yes/no буюу тийм/үгүй гэж хариулах асуултуудад анхааралтай хандаарай – буруу хариулснаар та виз авах эрхээ бүр мөсөн алдаж болно.







DS-160 маягт бөглөх

5-р алхат – Өргөдлөө нягтлан хянах

- Өргөдлөө мэдүүлэх буюу “submit” товчийг дархаас өмнө танд бүх хариултаа хянаж залруулага оруулах боломж байгаа.
- Бүх мэдүүлэгээ үнэн зөв эсэхийг сайтар шалгаарай. Учир нь дараа засвар оруулах боломжгүй юм.



DS-160 маягт бөглөх

6-р алхам – Өргөдөлөө мэдүүлэх

- Өргөдлийг “Sign and Submit” товч дарж мэдүүлснээс хойш ямар ч өөрчлөлт оруулах боломжгүй
- Өргөдөлд гарын үсэг зурж мэдүүлэх “Sign and Submit Application” товчийг сонгосноор таны электрон гарын үсэг үүсгэгдэх ба энэ нь өргөдөлд өгсөн бүх мэдүүлэг үнэн зөв гэдгийг батлаж байгаа таны гарын үсэг юм.



DS-160 маягт бөглөх

7-р алхам – Баталгаажуулах хуудсаа хэвлэж авах

- Баталгаажуулах хуудсаа **LaserJet** принтерээр хэвлэж авна
- Ярилцлаганд зөвхөн хэвлэж авсан баталгаажуулах хуудсаа авч ирнэ
- Өөртөө авч хадгалахыг хүсвэл өргөдлийг бүтнээр нь хэвлэж болно.
- Баталгаажуулах хуудсыг хэн нэгэн өөр хүн рүү имейлээр илгээж болно (жишээ нь хэрэв та хэн нэгний өмнөөс өргөдлийг бөглөсөн бол)

DS-160 маягт бөглөх

7-р алхам – Баталгаажуулах хуудас

- Таны баталгаажуулах хуудас ингэж харагдана
- Хэрэв стандарт шаардлага хангаагүйн улмаас зургаа оруулж чадаагүй бол та зургаа энд нааж ярилцлаганд авч ирнэ үү.



САНАМЖ:

DS-160 маягт нь зөвхөн өргөдлийн маягтуудыг орлож байгаа. Бусад бичиг баримтуудыг та б үрдүүлж ирэх шаардлагатай. Үүнд:

- Оюутнууд: I-20
- Солилцооны хөтөлбөрт оролцогсод: DS-2019
- Дипломатууд болон албан туушаалтнууд: дипломат нот бичиг

Виз мэдүүлэгчид АНУ-д цагаачлан үлдэхгүй, эх орондоо заавал эргэж ирэх шалтгаан байгаа гэдгээ нотлон харуулах.

Холбоо барих хаяг:

Консулын хэлтэс:

Вебсайт: http://mongolia.usembassy.gov/

Имейл: cons@usembassy.mn

Факс: 976-11-353788

Асуулт?

DS-160 маягтын талаархи
түгээмэл асуултуудын хариултыг энд дарж
үзнэ үү.